



ӨВОРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 56

Арвайхээр

Г Хөтөлбөр батлах тухай Т

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18.1.2-ийн “ж”, “Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 2 дугаар бүлгийн 10.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймагт хэрэгжүүлэх Хүмүүнлэгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хүмүүнлэгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүхий л талын туслалцаа дэмжлэг үзүүлэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, Улаан загалмайн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулахтай холбогдсон зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/, сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг аймгийн Улаан загалмайн хорооны дарга /Б.Энхцогт/-д үүрэг болгосугай.
4. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



100130113

D:\ITX\luuts 2019\1.togtool 2019\T hural\TOGTOOL- 2019.docx

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн
56. дугаар тогтоолын хавсралт

ХҮМҮҮНЛЭГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР
/2019-2024 ОН/

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

Сүүлийн жилүүдэд аймаг орон нутгийн хэмжээнд байгалийн гамшигт үзэгдэл болон хүн, малын гоц халдварт өвчин гарч, эрдэнэт хүний амь нас эрсдэх, осол гэмтэлд өртөх зэрэг аймгийн нийгэм, эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учруулсаар байна.

2012-2016 онд "Хүмүүнлэгийн дэд хөтөлбөр" хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрсэн боловч цаашид хүн амын эрүүл мэндийг хямралыг хөнгөвчлөх, гамшигийн бэлэн байдлыг хангаж, хор уршгийг багасгах, нэн эмзэг бүлгийн хүмүүст халамж, сэтгэл зүйн болон нэн шаардлагатай дэмжлэг үзүүлэх зэрэг хүмүүнлэгийн ажлын чанар, цар хүрээг тэлж, сайн дурын идэвхтэн гишүүд, олон нийтийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, Дунд шатны улаан загалмайн хорооны чадавхийг бэхжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын үйл ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Төрийн хүмүүнлэгийн бодлогын хүрээнд аймаг орон нутгийн төр захиргааны байгууллага, Улаан загалмайн хорооны хамтын ажиллагааг нэгдмэл байдлаар оновчтой зохион байгуулж, орон нутгийн иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, төрөөс үзүүлж буй нийгмийн халамжид хамрагдаж чадахгүй байгаа иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлэх, хүмүүнлэг энэрэнгүй шударга ёсны зарчмыг сурталчлан дэлгэрүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

- 3.1 Иргэдийн өөрийн болон бусдын амь насыг гамшиг, ослоос хамгаалах, сэргийлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаанд оролцоо, чадавх нөлөөлөл, гамшигийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг нэмэгдүүлэх
- 3.2 Зохих мэдлэг, дадлага олгох замаар эрүүл мэнд, аюулгүй амьдралыг эрхэмлэх, хандлагыг нэмэгдүүлэх
- 3.3 Хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэн дээдэлж, амар амгалан, хүмүүнлэг нийгмийн тогтолцоог орон нутагт хэвшүүлэх
- 3.4 Олон улсын улаан загалмайн хороо, олон улсын байгууллагуудтай түншлэл хамтын ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх
- 3.5 Дунд шатны улаан загалмайн хорооны тогтвортой байдлыг хангаж ажиллах

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1 Нэгдүгээр зорилтын хүрээнд:

4.1.1 Гамшигийн үед ажиллах эрүүл мэнд, анхны тусlamж, хангамж, хяналт үнэлгээ, тусlamж тараалт, мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр мэргэшсэн багийг ажиллуулах механизмыг бий болгох

4.1.2 Гамшигийн бэлэн байдлыг хангах, сэргийлэх, эрсдэлийг бууруулахад ард иргэд, аж ахуй нэгж, байгууллага, ерөнхий боловсролын сургууль түшиглэсэн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх

4.1.3 Гамшигт нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сайн дурын идэвхтэнүүдийг сургах, дадлагажуулах, бэлтгэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах

4.1.4 Гамшигийн үеийн яаралтай тусlamж, нөхөн сэргээх үйл ажиллагааны нөөц бүрдүүлэх хамтын ажиллагааны зохицуулалтыг идэвхжүүлж, хүчин чадлыг бэхжүүлэх

4.1.5 Аймаг орон нутгийн байгаль цаг уур, газар зүйн онцлогийг харгалzan, гамшигийн уршгийг бууруулах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд ард иргэд, малчидтай хамтран ажиллах.

4.2 Хоёрдугаар зорилтын хүрээнд

4.2.1 Осол гэмтлээс сэргийлэх, тохиолдож болох эрсдэл, хүндрэлүүдээс иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн олон нийтийн мэдлэг, дадлага, хандлагыг өөрчлөх

4.2.2 Олон нийтийн оролцоог дэмжиж, тэдний хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэнд, анхны тусlamжийн чиглэлээр орон нутгийн төр, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

4.2.3 Гамшиг, ослын үед анхны тусlamжийн үйлчилгээ үзүүлэх багийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж бодит үйлчилгээг бий болгох

4.2.4 Олныг хамарсан зарим халдварт өвчнүүдийн дэгдэлтийн үед халдварын тархалтыг бууруулахад дэмжлэг үзүүлэх

4.2.5 Аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг бүрдүүлэхэд сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх

4.2.6 Нөхөн үржихүйн эрүүл мэнд, ХДХВ/ДОХ-ын халдвараас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг сайжруулах

4.3 Гуравдугаар зорилтын хүрээнд:

4.3.1 Эмзэг бүлгийн иргэдийн тогтвортой амьжиргааны болон бие даасан байдал, нийгмийн сэтгэлгээний хандлагыг өөрчлөх замаар олон нийтэд тулгуурласан халамж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг эрчимжүүлэх

4.3.2 Халамж өргөөний үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах

4.3.3 Төрийн нийгмийн халамжийн үйл ажиллагааг гэрээгээр авч хэрэгжүүлэх

4.3.4 Сайн дурын идэвхтэний үйл ажиллагааны бодлого, хэрэгжилт, удирдлага менежментийг бүх шатанд сайжруулах

4.3.5 Өсвөр үе залуучуудын бүлэг, бүлгэм, клуб, тусч хамтлагийн үйл ажиллагааг сургууль түшиглэн өргөжүүлэн хөгжүүлэх

4.3.6 Хүмүүнлэгийн эрх зүйн боловсролын сургалтыг тогтмолжуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн өсвөр үе, хүүхэд залуучуудад хүмүүнлэг энэрэнгүй үзлийг төлөвшүүлэх

4.3.7 Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх

4.4 Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

4.4.1 Хөтөлбөрийн хугацаанд олон улсын байгууллагуудтай аймаг, сүм орон нутгийн түншлэлийг хөгжүүлэх, хамтран ажиллах бодлогыг хэрэгжүүлэх.

4.5 Тавдугаар зорилтын хүрээнд:

4.5.1 Хүмүүнлэг ардчилсан иргэний нийгмийг төлөвшүүлэхэд чиглэсэн төрийн үйлчилгээг Улаан загалмайн байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбогдсон санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг төр захиргааны байгууллагатай зөвшилцэн шийдвэрлэж хэвшилэх.

4.5.2 “Хүмүүнлэгийн хөтөлбөр” боловсруулан аймаг орон нутгийн төр захиргааны байгууллагатай жил бүр гэрээ байгуулж, санхүүгийн дэмжлэг авч ажиллах

4.5.3 Хөрөнгө арвижуулах, орлого нэмэгдүүлэх ажлын менежментийг боловсронгуй болгож хэрэгжүүлэх.

4.5.4 Байгууллагын хүчин чадал, тохижилт засвар үйлчилгээг стандартын дагуу хийж гүйцэтгэх.

4.5.5 Үйл ажиллагааны болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах бодлого төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

Тав. Хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн

5.1 Нэгдүгээр зорилтын хүрээнд хүлээгдэж буй үр дүн:

- Гамшигийн бэлэн байдал хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, нөхөн сэргээх үйл ажиллагааны менежмент сайжирна.
- Гамшигийн бэлэн байдлын талаарх ард иргэдийн мэдлэг, хандлага дээшилж гамшгаас сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдэнэ.
- Гамшигтай тэмцэх ажилд хүмүүнлэгийн байгууллагатай хамтран ажиллах төрийн бодлого, дэмжлэг, хамтын ажиллагаа дээшилнэ.

5.2 Хоёрдугаар зорилтын хүрээнд хүлээгдэж буй үр дүн:

- Халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нийгэм, иргэдийн мэдлэг хандлага, мэдээлэл сайжирч, олон нийтийн оролцоо, чадавх нэмэгдэнэ.
- Нийт хүн амын нэг хувь нь сайн дурын авлагагүй донорын эгнээнд нэгдэж, төрөөс тавих анхаарал, дэмжлэг сайжирна.
- Иргэд олон нийт өөртөө болон бусдад туслах анхны тусlamжийн мэдлэг, үр чадвар нэмэгдэж, осол гэмтлээс үүдэлтэй нас баралт болон өвчлөлийн тоо буурна.
- Нөхөн үржихүйн насны хүмүүсийн дундах бэлгийн эрүүл мэнд, ХДХВ-ын халдвараас сэргийлэх мэдлэг, хандлага сайжирна.

5.3 Гуравдугаар зорилтын хүрээнд хүлээгдэж буй үр дүн:

- Нэн эмзэг бүлгийнхэнд хүрч үйлчлэх үйл ажиллагааны, чанар, хамрах хүрээ нэмэгдэнэ.
- Нийгэм, хувь хүний оролцоо, хамт олонд тулгуурласан халамж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, санхүүгийн болон хүний нөөцийн чадавх, нөлөөлөл сайжирна.

- Хүмүүнлэгийн эрх зүйн мэдлэг нь өсвөр үе, хүүхэд залуучуудын хүмүүжилд төлөвшилд эерэг нөлөө үзүүлнэ.

5.4 Дөрөвдүгээр зорилтын хүрээнд хүлээгдэж буй үр дүн:

- Олон улсын хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоо, дэмжлэг, санаачилга, харилцан хамтын ажиллагаа идэвхижинэ.

5.5 Тавдугаар зорилтын хүрээнд хүлээгдэж буй үр дүн

- Хүмүүнлэгийн үйл ажиллагааг үр дүнтэй, хүртээмжтэй, шинэлэг арга аргачлалаар хэрэгжүүлэх нөөц, чадамж бүх шатанд эрчимжинэ.
- Хүмүүнлэгийн үйлсийн хамтын оролцоо, нэгдмэл байдал бэхжинэ.
- Санхүү хөрөнгийн тогтвортой, баталгаатай эх үүсвэр, нөөц нэмэгдэнэ.
- Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээ, тайлагналт бүх шатанд сайжирна.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

- 6.1 Жил бүрийн аймаг, орон нутгийн төсөв.
- 6.2 Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн хоёр талт хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аймагт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- 6.3 Аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон олон улсын байгууллага, иргэд олон нийтийн хандив тусламж.
- 6.4 Бусад эх үүсвэр.

---Оо---